

81

**“ХОРИН ХОЁР ДУГААР БААЗ” ХК-ИЙН ХУВЬ НИЙЛҮҮЛЭГЧДИЙН  
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

“ХОРИН ХОЁР ДУГААР БААЗ” ХК-ний хувь нийлүүлэгчдын ээлжит хурал 2015 оны 04 дугаар сарын 30-ний өдрийн 10 цагт “22-р Бааз” ХК-ийн хурлын зааланд болов. Хурлын ирц 73.4 % тай, хурал хүчин төгөлдөр болход хангалттай гэж үзээд хурлыг дэгийн дагуу хурлын даргаар Л.Гүндэгмааг, хурлын нарийн бичиг П.Эрдэнэчулуун тооллогын комиссоор Б.Баярсайхан, А.Ариунсайн нарыг томилохоор санал хэлэлцэж тогтоолын төслийг танилцуулсныг гишүүд санал нэгтгэйгээр батлав. Хурлын дарга Л.Гүндэгмаа хурлыг нээж мөн хурлын дэг хурлаар хэлэлцэх асуудлууд зэргийг уншиж танилцуулав.

*м дэвр-н  
дагуу  
шил*

1. Дэгийг танилцуулсаны дараа “ХОРИН ХОЁР ДУГААР БААЗ” ХК-ний Гүйцэтгэх захирал Л.Гүндэгмаа 2014 оны ТУЗ болон гүйцэтгэх захирлын ажлын тайланг танилцуулав.

2. Мөн дэгийн дагуу 2014 оны санхүүгийн тайлан тэнцлийг дэлгэрэнгүй ярьж танилцуулав.

3. Компанийн 2014 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайланг сонгож хэлэлцээд сайн гэж танилцуулав.

4. Компанийн хэлбрийг өөрчлөх асуудалыг дэмжив.

5. Компанийг өөрчлөн байгуулах төслийг санал нэгтгэйгээр дэмжив.

6. “22-р БААЗ” ХХК-н дүрэмийг батлав.

Хурлаар хэлэлцэх асуудлуудыг танилцуулсны дараа хурал хувь нийлүүлэгчдээс үг хэлэх, санал гаргах хэсэгтээ оров.

-З.Номундарь: Энэ жилдээ багтаад энхүү ажил шийдэгдэж амжих болов уу?

-Л.Гүндэгмаа: Бид энэ тал дээр найдаж байгаа л даа, ер нь хууль, журамын хүрээнд татгалзах зүйл байхгүй болов уу.

-Т.Эрдэнэбаатар: Компанийн хэлбэрийг өөрчлөх нь хэр ажилтай вэ? Энэ төсөл, дүрэм бүгд холбогдох хууль журамын хүрээнд биз дээ?

-Л.Гүндэгмаа: Энэ материалууд бүгд хууль, журамын хүрээнд боловсруулагдсан байгаа, одоо Санхүүгийн Зохицуулах Хороо шийд гаргана байх, бид бүхэн яг л хууль журамаа барьж ажилласан.

7. Бусад.

-З.Номундарь: Энэ компанийн үндсэн хөрөнгийн эдэлгээ, ашиглалтын хугацаа дууссан уу? Ер нь үндсэн хөрөнгөнд чинь хууль, журмаараа ашиглалтын хугацаа нь дууссан зүйлс яваад л байгаа харагдах юм.

-Л.Гүндэгмаа: Харин тийм байгаа, холбогдох төрийн байгууллагуудад нь хандаад үзүүлж актыг нь гаргуулах гэж албан хүсэлтээ өгчихсөн байгаа. 60-70 онд ашиглалтанд орсон, тэр үеэс ашиглаж ирсэн өмч хөрөнгүүд байгаа. Бид бүхэн үүнийг цэгцэлж, нэг тийш нь болгох гэж байгаа.

Өөр санал хэлэх хүн байна уу? Байхгүй бол саналаа хураая!

Хурлаар дээрх асуудлуудыг авч хэлэлцээд санал хураах хуудсаар санал хураав. Хурал түр завсарлаад санал хураах хуудсыг тоолж дүнг нэгтгэв. Хувь нийлүүлэгчдийн саналыг үндэслэн хурлаас гарах хувь нийлүүлэгчдийн хурлын тогтоолын төслүүдийг уншиж танилцуулан хуралд ирсэн гишүүдийн 100 хувийн саналаар тогтоолын төсийг баталснаар хурлын ажиллагаа өндөрлөв.

Протокол хөтөлсөн



/П.Эрдэнэчулуун/